



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2023.01.02 № 02

Нийгэм, эдийн засгийг сэргээх
хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар

КОВИД-19 цар тахал дэлхий нийтэд тархаж улс орнуудын нийгэм, эдийн засагт ихээхэн өөрчлөлтүүд гарсан юм. Монгол Улсын хувьд 2020 оны 3 дугаар сараас эхлэн анхны хөл хорио тогтоосноор КОВИД-19 цар тахлын дотоод эдийн засагт үзүүлэх нөлөө эхэлсэн гэж үздэг. Олон улсын туршлагад суурилан Монгол Улсын Их Хурал, Засгийн газар болон Монгол банкнаас эдийн засгийн хүндрэлээс сэргийлэх зорилгоор сангийн болон мөнгөний бодлогыг үе шаттайгаар авч хэрэгжүүлсэн.

Гэвч аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид, иргэдийн зүгээс Засгийн газраас хэрэгжүүлсэн аливаа хөтөлбөрийн дэмжлэг, хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чаддаггүй гэх гомдол саналууд ирж байгаа тул Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дэх заалт, 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дараах асуулгыг Танд хандан тавьж байна.

1. Монгол улсын Засгийн газраас нийгэм, эдийн засгийг дэмжих нийт 5.1 их наяд төгрөг зарцуулах багц арга хэмжээг 2020 оны 4 дүгээр сараас 2021 оны 7 дугаар сар хүртэл хэрэгжүүлсэн. Энэ багц арга хэмжээний дэлгэрэнгүй тайланг ирүүлнэ үү. Үүнд:

Аж ахуйн нэгжийг дэмжиж ажлын байр хадгалах зорилгын хүрээнд ямар салбарын ямар компанид хэрхэн дэмжлэг үзүүлсэн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2. "Төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолоор "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө"-г баталсан. Үүнээс:
 - Тогтоолын 2 дугаарт дурдагдсан банк санхүүгийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлсэн ажлын үр дүн, хэрэгжилтийн талаар;
 - Тогтоолын хавсралтад дурдсан 2 дугаар зорилгын 2.1 дэх арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд жилийн 3 хувийн хүүтэй 3 жилийн хугацаатай 3 их наяд хүртэлх зээлийг ямар аж ахуйн нэгж, салбарт олгосон, зээлийн эргэн төлөлтийн байдал;

2023000007

- Тогтоолын хавсралтад дурдсан 2 дугаар зорилгын 2.4-т дурдсан репо санхүүжилтийг ямар банкинд олгосон;
- Тогтоолын хавсралтад дурдсан 2 дугаар зорилгын 2.5-д дурдсан хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийг ямар аж ахуйн нэгжүүдэд хэрхэн олгосон;
- Тогтоолын хавсралтад дурдсан 2 дугаар зорилгын 2.7-д дурдсан "Өрхийн тариалан" хөдөлгөөн өрнүүлж, аж ахуйн нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг олгосон тухай дэлгэрэнгүй мэдээлэл;
- Тогтоолын хавсралтад дурдсан 2 дугаар зорилгын 2.10-д дурдсан хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох санхүүжилтийг ямар аж ахуйн нэгж, иргэдэд олгосон;
- Тогтоолын хавсралтад дурдсан 2 дугаар зорилгын 2.25-д дурдсан нийгмийн даатгалын шимгэлээс чөлөөлөх хуулийн хэрэгжилт;
- Тогтоолын хавсралтад дурдсан 2 дугаар зорилгын 2.28-д дурдсан гол нэрийн барааны зохиомол өсөлтөөс сэргийлэх санхүүжилтийг ямар аж ахуйн нэгжүүдэд олгосон, түүний хэрэгжилтийн үр дүнгийн талаар;

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан хугацаанд ирүүлж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



С.ОДОНТУЯА

2023000057